



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
ШУДАРГА ИРГЭДИЙН НЭГДСЭН
ЭВСЭЛ НАМД**

2020.08.10 № 213
танай _____ -ны № _____ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намын Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3. дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намын мөрийн хөтөлбөр /.....хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.САРАНТУЯА

008020352

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны
сонгуульд оролцох Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл Намын

Мөрийн хөтөлбөр

Ерөнхий зүйл: УИХ-н 2020 оны ээлжит сонгуульд “ШИНЭ нам, Бүгд Найрамдах нам, Үнэн ба Зөв нам, Монгол Үндэсний Ардчилсан намуудын ШИНЭ ЭВСЭЛ”-ээс дэвшүүлсэн “ШИНЭ ЭРГЭЛТИЙН БОДЛОГО-21” мөрийн хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхийг үндсэн зорилтоо болгон ажиллана.

Хамтдаа хөгжих 10 зорилт:

1. Орон нутагт намчирхал, талцалыг таслан зогсооно.
2. Орон нутгийн төсвийн зарцуулалтад хатуу хяналт тогтооно.
3. Аливаа асуудал, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхдээ тухайн орон нутгийн иргэдэд мэдээллийг урьдчилан танилцуулж, нээлттэй, өргөн хэлэлцүүлэг хийсний дараа шийдвэр гаргадаг жишгийг тогтооно.
4. Орон нутгийн ИТХ, Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг мэдээллийн бүхий л хэрэгсэл, олон нийтийн сүлжээг ашиглан тогтмол мэдээллэж, байнгын, бодит, өгөөжтэй эргэх холбоог бий болгоно.
5. Тухайн орон нутгийн иргэдийн хамтарч, хоршиж ажиллах аливаа санал, санаачлагыг дэмжиж ажиллана.
6. Иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хөнгөн шуурхай, хүнд сурталгүй, хялбар, энгийн ойлгомжтой болгох талаар төрийн захиргааны байгууллагууд болоод тухайн тойргоос сонгогдсон УИХ-н гишүүдтэй нягт хамтран ажиллана.
7. Нийтийн өмч, зам талбайн ашиглалт, хамгаалалт, эрүүл ахуйн нөхцөл байдал, орчны аюулгүй байдлын хяналт, шалгалтад тухайн орон нутгийн иргэдийн сайн дурын оролцоог эрс нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.
8. Төв суурин газрын гудамж, орчны тоосжилтыг эрс бууруулах талаар иргэдийн оролцоонд суурилсан санаачлага гарган ажиллана.
9. Хүүхдийн тоглох, суралцах орчины эрүүл, аюулгүй орчныг хангах зорилтыг тэргүүлэх бодлого болгоно.
10. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрөөс үзүүлдэг халамжаас гадна тухайн орон нутгийн иргэд хамтран сайн дурын үндсэн дээр нэгдэж халамж тусалцаа үзүүлдэг тогтолцоог хэвшүүлэх ажиллагааг санаачлан эхлүүлнэ.

021713443
/CA0055 9013

000000001